

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/11-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Мөнхзул Утас: 7036-2442 Цахим хаяг: Munkhzult@audit.gov.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. Аудитын санал, дүгнэлт	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
1. Аудитын тайлан	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	12
3.5.4 Үндсэн хөрөнгө	14
Аудитын илрүүлэлт:	15
3.5.5 Өр төлбөр	15
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5.8 Зардлын данс	16
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	24
3.8 Аудитын гол асуудал	24
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
2. 4. Аудитын илрүүлэлт	26
3. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	34



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040. Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № 107-2022/11-НА-СТА-ТТЗ
Тайлбар _____-ийм № _____-т

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б. МӨНХБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

ТТЗахирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос зайлшгүй шаардлага үүсээгүй байхад компьютер, тоног төхөөрөмж худалдан авах болон урсгал зардлын төсвийг нийт 24,880.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн,
- ИТХ-аар баталсан сумын ЗДТГ-ын төсвийн санхүүжилтийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 39,211.5 мянган төгрөгөөр илүү тусгаж, тайлагнасан.

ЗДТГ:

- Баяр наадмын зардлын хэмнэлтээс төрийн жинхэнэ албан хаагчдад 3,750.0 мянган төгрөгийн албаны дүрэмт хувцас захиалж, хийлгүүлсэн,
- Батлагдсан төсвөөс тус суманд албан томилолтоор ажилласан аймгийн МЭГ-ын ажилтнуудын зочид буудлын хөлс 60.0 мянган төгрөгийг төлсөн,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 12,486.0 мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан.

ИТХ:

- Хөтөл дөнт шүдний эмнэлэгт 300.0 мянган төгрөг, ХБИ-ийн хоол хүнсний дэмжлэгт 200.0 мянган төгрөг, нийт 500.0 мянган төгрөгийн хандив өгсөн.

Сумын ЭМТ:

- Нэр бүхий 3 ажилтны ажилласан цагийг илүү тооцон 455.1 мянган төгрөгийн цалин, эмнэлгийн дарга Н.Мөнхтунгалагт 973.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс / *хоногт 24 цаг ажилласнаар* / зэрэг нийт 1,428.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- Төсвийг зориулалт бусаар буюу нэмэлт санхүүжилтийн НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардалд 3,120.9 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажил олгогчийн шийдвэргүйгээр 8 албан хаагчид 1,782.0 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.

Номгон тосгоны ЭМТ:

- Эмийн тооцоо, тооллогыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс нийт 2,328.0 мянган төгрөгийн / *эмнэлгийн дотоод эм 187.3 мянган төгрөг, эмийн сангийн эм 2,140.7 мянган төгрөг* / эмийн дутагдал үүсгэсэн,
- Эмийн сангийн эмийн орлого нь шилжүүлсэн төлбөрөөс 9,916.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан буюу төлбөрийг гүйцэтгэсэн эм бэлтгэн нийлүүлэгдээгүй,
- Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллого хийж хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй
- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 4,941.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Эмийн сангийн 2,372.2 мянган төгрөгийн эмийн худалдан авалтыг эмийн тайланд орлого авалгүйгээр зарцуулсан,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ЭМТ-ийн даргад 1,279.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон,
- Эмийн сангийн 18,943.5 мянган төгрөгийн эмийн борлуулалтыг зарлагаар бүртгэлгүйгээр үлдэгдлээр тайлагнасан,

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын 511.8 мянган төгрөгийн, НДШ-ийн 193.9 мянган төгрөгийн зэрэг нийт 705.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- 3 албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 2,100.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.

Номгон тосгоны Соёлын төв:

- Эрхлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламжтай давхардуулан 895.9 мянган төгрөгийн тусламжийг цалингийн сангаас олгосон.

Сумын Соёлын ордон:

- Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлснээс 2,307.0 мянган төгрөгийн авлага, бараа материалын төлбөрийг дутуу шилжүүлснээс 1,610.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

1 дүгээр сургууль, 1,2 дугаар цэцэрлэг:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас нийт 2,537.0 мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 34 дугаар зүйлийн 34.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 5.2 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. Энхтуяа

Ч.ЭНХТУЯА

2.Аудитын санал, дүгнэлт**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,222,794.50	2,141,268.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	244,492.00	493,951.30
33	АВЛАГА	456,576.20	972,075.10
35	БАРАА МАТЕРИАЛ	521,726.40	675,241.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,296,345.50	15,173,229.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,296,345.50	15,173,229.60
39200	Биет хөрөнгө	13,677,387.20	14,487,798.30
39300	Биет бус хөрөнгө	618,958.30	685,431.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,519,140.00	17,314,497.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	435,912.40	523,070.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	435,912.40	523,070.10
41300	Өглөг	435,912.40	523,070.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,083,227.60	16,791,427.50
51	Засгийн газрын хувь оролцоо	15,083,227.60	16,791,427.50
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,246,976.50	4,016,431.00
51200	Хуримтлагдсан үр дүн	3,725,223.70	2,991,634.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,111,027.40	9,783,362.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,519,140.00	17,314,497.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,456,245.50	11,473,766.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	519,933.20	621,805.20
110	Орлогын албан татвар	228,868.30	279,456.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	228,868.30	279,456.20
113	Хөрөнгийн албан татвар	1,541.00	54,761.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	289,523.90	287,588.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,046,910.50	1,152,436.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,046,910.50	1,152,436.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,889,401.80	9,699,524.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,027,450.70	10,197,850.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,027,450.70	10,197,850.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,274,785.00	9,780,726.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,245,972.50	5,333,440.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	529,848.20	700,968.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	973,154.60	1,209,537.60
2104	Хангамж, бараа материалын зардал	131,506.90	193,827.70
2105	Нормативт зардал	130,785.20	636,895.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,440.40	189,043.20
2107	Томилолт, зочны зардал	11,571.30	8,873.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	252,056.40	338,919.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	952,449.40	1,169,219.70
212	ТАТААС	14,280.00	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,738,385.80	417,124.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	428,794.70	1,275,916.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	231,327.60	267,707.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)	197,467.20	1,008,208.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	9,640,209.70	10,028,253.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	519,933.20	621,805.20
110	Орлогын албан татвар	228,868.30	279,456.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	228,868.30	279,456.20
113	Хөрөнгийн албан татвар	1,541.00	54,761.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	289,523.90	287,588.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	281,283.20	266,120.50
1181	Газрын төлбөр	8,165.60	18,154.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	75.1	3,312.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,874.70	283,978.20
120	Нийтлэг татварын бус орлого	230,874.70	283,978.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,889,401.80	9,122,469.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,227,033.00	9,154,586.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,227,033.00	9,154,586.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,470,566.90	8,736,305.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,244,500.90	5,336,279.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	529,568.70	700,968.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,011,843.70	1,136,815.30
2104	Хангамж, бараа материалын зардал	114,585.30	169,258.50
2105	Нормативт зардал	127,348.20	694,623.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,302.00	195,987.30
2107	Томилолт, зочны зардал	11,571.30	8,873.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	251,385.70	339,814.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,461.00	153,684.40
212	ТАТААС	14,280.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,742,186.10	418,281.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	413,176.70	873,666.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	372,867.20	529,207.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	372,867.20	529,207.30
2200	Дотоод эх үүсвэрээр	372,867.20	529,207.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(372,867.20)	(529,207.30)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(85,000.00)	(95,000.00)
14	Бусад эх үүсвэр	0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	85,000.00	95,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(44,690.40)	249,459.40

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	289,182.40	244,492.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	244,492.00	493,951.30

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,885,760.40	14,885,760.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	10,808.50	10,808.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,896,568.90	14,896,568.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,808.50)	(10,808.50)
9	Тайлант үеийн үр дүн	197,467.20	197,467.20
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,083,227.60	15,083,227.60
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,083,227.60	15,083,227.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	692,631.90	692,631.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,775,859.50	15,775,859.50
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	12,184.00	12,184.00
19	Тайлант үеийн үр дүн	1,008,208.80	1,008,208.80
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	16,791,427.50	16,791,427.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,000,044.30	8,531,711.62	468,332.68	94.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,419,136.80	8,107,187.98	311,948.82	96.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,251,630.70	7,964,918.68	286,712.02	96.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,267,754.20	5,100,593.78	167,160.42	96.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	701,127.10	671,191.63	29,935.47	95.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,151,144.30	1,136,815.34	14,328.96	98.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	127,935.30	126,642.21	1,293.09	99.0%
2105	Нормативт зардал	331,874.30	284,403.01	47,471.29	85.7%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	243,348.50	243,199.72	148.78	99.9%
2107	Томилолт, зочны зардал	11,374.20	8,434.40	2,939.80	74.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,756.00	281,853.54	10,902.46	96.3%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,316.80	111,785.03	12,531.77	89.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167,506.10	142,269.30	25,236.80	84.9%
2132	Бусад урсгал шилжүүлэг	167,506.10	142,269.30	25,236.80	84.9%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	485,907.50	329,523.64	156,383.86	67.8%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000.00	95,000.00	0.00	100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,000,044.30	8,635,229.59	364,814.71	95.9%

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,642,724.70	5,486,472.62	156,252.08	97.2%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,155,146.60	2,929,401.47	225,745.13	92.8%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,427.20	74,763.60	11,663.60	86.5%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	115,745.80	144,591.89	(28,846.09)	124.9%
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	15	15		
610001	Төсвийн байгууллага	15	15		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	437	437		
620001	Удирдах ажилтан	29	29		
620002	Гүйцэтгэх ажилтан	253	253		
620003	Үйлчлэх ажилтан	148	148		
620004	Гэрээт ажилтан	7	7		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,788	2,617		
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,003	2,003		
630001	Төрийн өмчит ЕБС	2,003	2,003		
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	785	614		
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	785	614		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,086,620.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	994,554.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,110.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,685.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,776.69
2104	Хангамж, бараа материалын зардал	43,266.08
2105	Нормативт зардал	410,220.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,755.75
2107	Томилолт, зочны зардал	439.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,961.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,005.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,443.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,843.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,065.70
2200	Дотоод эх үүсвэрээр	92,065.70
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,086,620.11
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,086,620.11
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,096.04
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,877.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,393.52
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,364.71
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	810,888.34

1. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Сайхан сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, автомашины шатахууны нормыг шинэчлэн тогтоох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/98 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хууль тогтоомж, төр Засгийн бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн оновчтой бодлого зохицуулалтаар ханган төрийн албаны стандартыг бүрэн хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,

- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Сайхан сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчаас дотоод аудит хийгдээгүй байна.

ТТЗ-ийн удирдлагын зүгээс тайлант онд хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 10,197,850.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 101,978.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг

байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 71,384.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 244,482.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 493,951.3 мянган төгрөг болж, 249,459.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	9.0	-	-9.0	-
Төрийн сангийн харилцах	244,482.9	493,951.3	249,459.4	50.5
Хадгаламж	-	-	-	-
Дүн	244,482.9	493,951.3	249,468.4	50.5

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дэх 348,441.5 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 75,037.5 мянган төгрөг СХС-ийн дансанд, 64,597.9 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 4,311.9 мянган төгрөг ЭМТ-үүдийн дансанд, 1,562.5 мянган төгрөг барьцаа хөрөнгийн дансанд тус тус тайлагнагдсан байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 456,576.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 972,075.1 мянган төгрөг болж, 515,498.6 мянган төгрөгөөр өсчээ.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой авлага		2,874.7	2,874.7
Татаас санхүүжилтийн авлага		577,055.2	577,055.2
Зээлийн хүүгийн авлага	33,833.2	19,690.7	(14,142.5)
Байгууллагаас авах авлага			-
Хувь хүнээс авах авлага	6,765.6	6,765.6	-
Зээлийн авлага	415,977.4	365,688.9	(50,288.5)
Дүн	456,576.2	972,075.1	515,498.9

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 515,498.9 мянган төгрөгийн өсөлтөд ЭМТ-ийн ЭМДС-аас авах ковидын санхүүжилтийн авлага 577,055.2 мянган төгрөгөөр, ажиллагчидтай холбогдсон авлага 2,874.7 мянган төгрөгийн өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 39.6 хувь буюу 385,379.6 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Авлагын насжилтыг авч үзвэл

- ЭМДС-аас авах 577,055.2 мянган төгрөг тайлант онд үүссэн,
- СХС-ийн авлагаас 202,591.0 мянган төгрөгийн авлага нь 5-6 жилийн,

- ОНӨО дансанд бүртгэлтэй иргэдэд олгосон 1,582.3 мянган төгрөгийн итгэлийн зээлийн авлага 11-12 жилийн,
- Иргэдэд зээлээр өгсөн өвсний 3,104.3 мянган төгрөгийн авлага 10-11 жилийн,
- Сайхан 1 дүгээр сургуулийн дансанд бүртгэлтэй байгаа 698.9 мянган төгрөгийн цалингийн авлага 16 жилийн насжилттай байна.

Насжилт өндөртэй авлагууд нь тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй, эзэн холбогдогч тодорхойгүй, нас барсан зэрэг шалтгаанаас эргэн төлөгдөх боломжгүй байдалд хүрсэн байна.

Тайлант онд Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг шивж оруулснаар СХС-ийн зээлийн эргэн төлөлт сайжирч эргэлтийн эх үүсвэр нэмэгдэж байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас дараах байгууллагууд авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- Сайхан 1-р цэцэрлэг 175.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын,
- Сайхан 2-р цэцэрлэг 392.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын,
- Сайхан Соёлын төв 2,307.0 мянган төгрөгийн НДШ-ийн гэх мэт.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 521,726.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 675,241.6 мянган төгрөг болж, 153,515.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	49,466.5	47,946.6	(1,519.9)
Эм боох материал	15,021.2	87,578.2	72,557.0
Бичиг хэргийн материал	3,818.6	13,163.6	9,344.9
Аж ахуйн материал	298,361.4	306,915.4	8,554.0
Сэлбэг хэрэгсэл	126.1	2,623.3	2,497.2
Түлш, шатах тослох материал	2,383.7	1,927.1	(456.6)
Барилгын засварын материал	7,975.2	9,443.2	1,468.0
Хүнсний материал	1,160.9	19,677.1	18,516.2
Бэлэн бүтээгдэхүүн		99.0	99.0
Бусад хангамжийн материал	143,412.8	185,868.1	42,455.3
Дүн	521,726.4	675,241.6	153,515.2

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1,334,431.9 мянган төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан бол 125,052.6 мянган төгрөгийн материалыг хандив болон үнэ төлбөргүйгээр, 42,706.1 мянган төгрөгийн материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авч нийт 1,502,190.6 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн байна.

Харин үйл ажиллагаанд 1,288,887.2 мянган төгрөгийн материалыг зарцуулж, санхүүгийн тайлангийн аудитын явцад 46,115.2 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн залруулж, цаашид ашиглах боломжгүй 13,672.9 мянган төгрөгийн хөрөнгийг зохих шийдвэрийн дагуу акталж данс бүртгэлээс хассан зэрэг нийт 1,348,675.3 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын нийт 853,969.2 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй байна Үүнд:

- Сайхан ЗДТГ 55,042.9 мянган төгрөгийн,
- Номгон ЭМТ 29,765.9 мянган төгрөгийн,
- Сайхан Соёлын төв 20,208.1 мянган төгрөгийн,
- Сайхан ИТХ 3,752.9 мянган төгрөгийн,
- Номгон Захирагчийн алба 17,174.2 мянган төгрөгийн,
- Номгон Соёлын төв 657.3 мянган төгрөгийн,
- Хот тохижуулах газар 7,942.7 мянган төгрөгийн,
- Сайхан 1 дүгээр сургууль 89,990.7 мянган төгрөгийн,
- Сайхан 2 дугаар сургууль 88,997.2 мянган төгрөгийн,
- Сайхан ЭМТ 222,834.5 мянган төгрөгийн,
- Сайхан 1 дүгээр цэцэрлэг 88,342.7 мянган төгрөгийн,
- Сайхан 2 дугаар цэцэрлэг 83,136.4 мянган төгрөгийн,
- Сайхан 3 дугаар цэцэрлэг 31,562.3 мянган төгрөгийн,
- Сайхан 4 дүгээр цэцэрлэг 78,026.6 мянган төгрөгийн,
- Номгон тосгоны сургууль 36,534.6 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл / анхны өртгөөр / 16,736,483.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 19,320,268.7 мянган төгрөг болж, 2,583,785.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл / анхны өртгөөр /

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	12,053,452.7	12,968,289.8	914,837.1
Авто-тээврийн хэрэгсэл	332,723.1	397,155.3	64,432.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	996,900.0	1,762,909.8	766,009.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	512,606.8	620,039.9	107,433.2
Зам, гүүрийн байгууламж	20,381.4	20,381.4	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	59,500.0	59,500.0	-
Дуусаагүй барилга байгууламж	36,465.0	-	(36,465.0)
Бусад үндсэн хөрөнгө	2,093,399.5	2,791,651.2	698,251.7
Ном	4,192.6	4,780.4	587.8
Программ хангамж	16,268.7	29,978.7	13,710.0

Бусад биет бус хөрөнгө	610,593.7	665,582.1	54,988.4
Дүн	16,736,483.6	19,320,268.7	2,583,785.1

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 338,777.7 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, хандив болон бүтцийн өөрчлөлтөөр 1,684,141.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан, дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй байсан сумын ерөнхий төлөвлөгөө 36,465.0 мянган төгрөгийн үлдэгдлийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, бараа материалын данснаас шилжиж ирсэн 46,115.2 мянган төгрөг, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 656,715.7 мянган төгрөгийн ажлыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж орлогоор бүртгэсэн 49,030.9 мянган төгрөг зэрэг нийт 2,811,246.3 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Цаашид ашиглах боломжгүй, өртгөө бүрэн нөхсөн 190,996.2 мянган төгрөгийн хөрөнгийг зохих шийдвэрийн дагуу акталж данс бүртгэлээс хассан, дуусаагүй барилга байгууламжийн данснаас 36,465.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн зэрэг нийт 227,461.2 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Номгон тосгоны цэцэрлэг УТХО-аар хийгдсэн 208,737.5 мянган төгрөгийн өртөгтэй дээврийн их засварын ажлын дүнгээр хөрөнгийг капиталжуулаагүй,

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 435,912.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 523,070.1 мянган төгрөг болж, 87,157.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн/Буурсан
Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,610.2	1,610.2
Байгууллагад төлөх өглөг	435,912.4	521,459.9	85,547.5
Нийт дүн	435,912.4	523,070.1	87,157.7

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл нь голчлон халаалтын үнийн зөрүүгээс үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй өглөг, авлага ба төлбөрийн тооцоог урьдчилан хянаагүйн улмаас дараах байгууллагууд өглөг үүсгэж, тайлагнасан байна. Үүнд:

- Сайхан Соёлын төв 1,610.2 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн,

- Сайхан 1 дүгээр сургууль татварын тайланд цалингийн сана 785.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, нийгмийн даатгалын шимтгэлийг 1,268.2 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон, хамтын сангийн урьд оны өглөг 190.8 мянган төгрөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- Сайхан ЭМТ нь тайлант жилийн эцэст НДШ, ХХОАТ-ын тооцоог сайн хянаагүйгээс НДШ, ХАОАТ-ыг 1,933.0 мянган төгрөгөөр, Номгон ЭМТ 705.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 15,083,227.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 16,834,022.4 мянган төгрөг болж, 1,750,794.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/н бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,246,976.50	4,016,430.50	769,454.00
Хуримтлагдсан үр дүн	3,725,223.60	3,034,229.50	-690,994.10
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,111,027.40	9,783,362.40	1,672,335.00
Дүн	15,083,227.50	16,834,022.40	1,750,794.90

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь Сайхан ЭМТ- нь бүтцийн өөрчлөлтөөс хамааран орон нутагт шилжсэн болон хуримтлагдсан үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд ЗДТГ 4,304.5 мянган төгрөгийн, соёлын төвүүд 3,722.6 мянган төгрөг, Сайхан 1 дүгээр сургууль 5,383.6 мянган төгрөг, Сайхан ЭМТ 34,904.0 мянган төгрөг, СХС-ийн эргэн төлөлт 96,227.1 мянган төгрөг зэрэг нийт 144,591.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 143,231.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ :

- ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан ЗДТГ-ын төсвийг 39,221.5 мянган төгрөгөөр нэмж тайлагнасан.

ИТХ:

- Хөтөл дөнт шүдний эмнэлэгт дэмжлэг 300.0 төгрөг, ХБИ-дэд хүнсний дэмжлэг 200.0 мянган төгрөгийн хандив өгсөн.

ЗДТГ:

- Албан томилолтоор ажилласан аймгийн МЭГ-ын албан хаагчдын зочид буудлын хөлс 60.0 мянган төгрөгийг төлсөн.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс уралдаан тэмцээн, тэмдэглэлт ой, албан хаагчид болон хүүхдийн бэлэг зэрэг 12,486.0 мянган төгрөгийн зарцуулалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүйгээр зөвхөн захирамжийг үндэслэн гаргасан.
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь бодитоор төлөвлөөгүйгээс 180,9 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй
- Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн тодотгол хийж, зардлыг 24,880.0 мянган төгрөгөөр нэмж баталсан.
- Баяр наадмын батлагдсан төсвөөс ЗДТГ-ын ажилтнуудад / жижүүр, үйлчлэгчдийг хассан дүн / 3,750.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас захиалж хийлгэсэн,

Номгон ЭМТ:

- Нэр бүхий 3 ажилтны эзлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс 2,100.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.
- Анхан шатны баримтгүй 4,941.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан,
- Эмийн сангийн 2,372.2 мянган төгрөгийн эмийн худалдан авалтыг орлогын тайланд тусгалгүйгээр зарцуулсан.
- Эмийн сангаас эм худалдан авахад 9,916.3 мянган төгрөг зарцуулсан боловч нийлүүлэгдээгүй.
- ЭМТ-ийн даргад холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр 1,279.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
- Эмийн сангийн эмийн орлого, зарлагын тооцоог хянаж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс 2,328.0 мянган төгрөгийн эм, хэрэгсэл дутагдсан.
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан эмийн сангийн 18,943.5 мянган төгрөгийн эмийн зарлагыг бүртгэлгүй, хөрөнгийн үлдэгдэлд тайлагнасан,
- Зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд 189.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй,
- Санхүүгийн тайланд эм, эмнэлгийн хэрэгслийн эхний үлдэгдлийг өртгөөр нь бус худалдах үнээр нь тусгаснаас 2,483.4 мянган төгрөгөөр хөрөнгийн үлдэгдлийг өсгөж тайлагнасан,
- Тайлант онд эд хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй,

Номгон Соёлын төв:

- Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид цалингийн зардлаас 895.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон,

Сайхан 1 дүгээр сургууль:

- Скайтел компаниас лизингээр авсан утасны үнэ 510.2 мянган төгрөгийг төсвөөс төлсөн,
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь бодитоор төлөвлөөгүйгээс 3,993.6 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй,

Сайхан 2 дугаар сургууль:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь бодитоор төлөвлөөгүйгээс 723.3 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй,

Сайхан ЭМТ:

- Ажилтнууд эзлэгийн амралтыг биеэр эдлээгүйгээс 1,782.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон,
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв бүртгээгүйгээс 3,120.9 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй,
- Ажилтнуудын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр нийт 5,144.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон,
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас 1,428.9 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон,

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сайхан сумын ИТХ-ын 2021 оны 08 сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Сайхан сумын 2021 оны тодотгосон төсөв” баталж, тайлант оны татварын орлогыг 499,179.0 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 140,000.0 мянган төгрөгөөр, нийт 639,179.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 760,272.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 18.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	499,179.00	621,886.10	122,707.10	124.6

Үйл ажиллагааны орлого	70,000.0	98,767.4	28,767.4	141.1
Хөрөнгийн орлого	82,500.0	95,065.9	12,565.9	115.2
Хөрөнгө борлуулсны орлого	50,000.0	85,652.7	35,652.7	171.3
Бууны албан татвар	3,100.0	1,884.0	-1,216.0	60.8
Малын тоо толгойн албан татвар	20,000.0	52,876.9	32,876.9	264.4
Улсын тэмдэгтийн хураамж	35,000.0	25,633.9	-9,366.1	73.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	181,000.0	209,353.9	28,353.9	115.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	40,000.0	31,132.6	-8,867.4	77.8
Газрын төлбөр	17,439.0	18,154.8	715.8	104.1
Ойн нөөц ашигласны төлбөр	140.0	55.0	-85.0	39.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		55.0	55.0	
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		3,254.0	3,254.0	
Татварын бус орлого	140,000.0	138,386.2	1,613.8	98.8
Торгуулийн орлого	120,000.0	129,665.1	-9,665.1	108
Бусад орлого	20,000.0	8,721.1	11,278.9	44
Нийт орлогын дүн	639,179.0	760,272.3	124,320.9	118.9

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд үйл ажиллагааны орлого 28,767.4 мянган төгрөг, хөрөнгийн орлого 12,565.9 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 35,652.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 32,876.9 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 28,353.9 мянган төгрөг, газрын төлбөр 715.8 мянган төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 3,254.0 мянган төгрөг, татварын бус бусад орлого 11,278.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Үйл ажиллагааны орлого: Тайлант онд хувиараа хадлан бэлтгэгчдийн өвсний борлуулалт нэмэгдэж, хувь хүний орлогын албан татвар төлснөөс шалтгаалсан,
- Хөрөнгө борлуулсны орлого: Иргэдийн эзэмшиж, өмчилж буй газар болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалт төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Хөрөнгө борлуулсны орлого: Өмнөх онд төлүүлэхээр ногдуулсан албан татварын орлогыг тайлант онд төвлөрүүлсэн,
- Малын тоо толгойн албан татвар: Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд үндэслэлгүй төлөвлөлтөөс шалтгаалж төлөвлөсөн орлого давж биелсэн,
- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр: Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн бэлчээрийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх албан шаардлагыг хэрэгжүүлж эхэлснээс шалтгаалсан,

- Татварын бус орлого торгуулийн орлого: Зөрчлийн тухай хуулийн хүрээнд ногдуулсан торгуулийн орлого давж биелсэн.

Тасарсан орлого:

- Бууны албан татвар: Галт зэвсэг эзэмшигч иргэн, аж ахуй нэгжийн тоо нь Цагдаагийн газар болон Татварын албаны бүртгэл зөрүүтэй байдгаас төлөвлөлтийг үндэслэлгүй хийсэн.
- Улсын тэмдэгтийн хураамж: Төлөвлөлтийг үндэслэл муутай хийснээс шалтгаалсан байна.
- Хог хаягдлын хураамж: Ковид-19 цар тахалтай холбоотойгоор иргэн аж ахуйн нэгжийн хог хаягдлын хураамжийг Засгийн газраас бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан.
- Ойн нөөц ашигласны төлбөр: Төлөвлөлтийг орон нутгийн газрын байршил, ойн нөөцийг харгалзаж хийдэггүй, аймгаас шууд төлөвлөгөө өгдгөөс шалтгаалсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,806,455.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 8,806,455.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналыг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 576,179.0 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 144,925.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 2,057,648.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 279,476.2 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 5,573,684.8 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 87,600.0 мянган төгрөг, ЭМД сангаас санхүүжих 86,427.2 зэрэг нийт 8,805,940.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор сумын төсвийг 154,892.6 мянган төгрөгөөр нэмж тодотгон 8,960,832.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Уг тогтоолоор дараах өөрчлөлтүүд оржээ. Үүнд:

Орлого талд:

Сумын татварын орлогын төлөвлөгөөг хөрөнгө, хөрөнгө борлуулсны албан татварыг 45,000.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 18,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 63,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Зарлага талд: 164,476.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 78,723.6 мянган төгрөгөөр бууруулж нийт дүнгээр нэмж тодотгосон. Үүнд:

- ИТХ-д компьютер тоног төхөөрөмж авах зардалд 2,000.0 мянган төгрөгийг,

- Хот тохижуулах газрын тогтмол зардал болон хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 30,253.5 мянган төгрөг,
- ЗД-ын нөөц хөрөнгөд 20,000.0 мянган төгрөг,
- Аврах гал унтраах 61-р ангид дрон худалдан авахад 2,880.0 мянган төгрөг,
- Төв талбайн урсгал засварт 35,000.0 мянган төгрөг,
- Өмгөөллийн хөлс 2,000.0 мянган төгрөг,
- ЗДТГ-ын дээврийн болон өрөө тасалгааны урсгал засвар, тоног төхөөрөмж авахад 7,788.4 мянган төгрөг ,
- СХС-д 13,670.0 мянган төгрөг,
- ОНХС-д 10,475.8 мянган төгрөг
- Сайхан сумын 1,2,3 дугаар цэцэрлэгийн халаалтын өр барагдуулахад 30,408.5 мянган төгрөгийг
- ЭМТ-үүдийн урсгал засварт 10,000.0 мянган төгрөгийг,

Бууруулсан зардал : Сайхан 2-р сургуулийн тогтмол зардлын хэмнэлт 31,147.8 мянган төгрөг, Спорт клуб аймгийн БТСГ-ын харьяанд шилжсэнтэй холбоотойгоор тус байгууллагын төсөв 28,862.9 мянган төгрөг, Сайхан Соёлын төвийн төсөвт тусгагдсан тэтгэмж 18,712.9 мянган төгрөг нийт 78,723.6 мянган төгрөгийг бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 8,960,832.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,379,925.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 485,907.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 95,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр ТШБ-уудын санхүүжилт 5,486,472.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,649,925.3 мянган төгрөг, ОНХС-аас 279,476.2 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт болон төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлого зэргээс 144,591.9 мянган төгрөг, ЭМДС-аас 74,763.6 мянган төгрөг зэрэг нийт 8,635,229.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,531,711.6 мянган төгрөг буюу 95.2 хувьтай тайлагнагдсан нь ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болон харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нийт 197,096.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14,329.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1,293.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 47,471.3 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 148.7 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 2,939.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 10,902.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 12,531.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 156,383.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хэдийгээр зардал нийт дүнгээр хэмнэгдсэн боловч цалингийн нэмэгдэл 8,449.1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардал 63,332.2 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардал 1,980.5 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамж 430.3 мянган төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардал 1,736.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар 5, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 4, нийт 9 төсөл, арга хэмжээнд 451,431.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 329,523.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож 121,908.1 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас 181,393.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 48,364.7 мянган төгрөг, иргэн хуулийн этгээдээс Ковид-19 цар тахалтай тэмцэхэд өгсөн хандив 40,096.0 мянган төгрөг, ЗГН, аймгийн ЗДНХ-өөс 5,877.5 мянган төгрөг, Ковид цар тахлын санхүүжилт болох ЭМДС-аас 810,888.4 мянган төгрөг, нийт 1,086,620.1 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд:

1. ЗДТГ нийт -52,241,9 мянган төгрөг:

- Замын сангийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 32,000.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/394 тоот захирамжаар Малын гоц халдварт өвчний ариутгал халдваргүйтгэлийн зардал 5,000.0 мянган төгрөг,
- Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллого, ААНБ-ын тооллогын санхүүжилт 1,340.9 мянган төгрөг,
- Цахим тендерийн орлого 1,225.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/291 тоот захирамжаар Цэрэг татлагын хоолны зардал 1,257.0 мянган төгрөг,
- Ковидын нөхцөл байдлаас хамааран иргэн ААНБ-ын хандив 8,019.0 мянган төгрөг,
- Хүүхэд хамгааллын төсөл хөтөлбөрийн санхүүжилт 2,700.0 мянган төгрөг,
- Аймгийн МЭГ-аас шүлхий өвчний тандалт, судалгааны шатахууны зардалд 500.0 мянган төгрөг,
- ХХААГ-аас ургац тогтоолтын шатахуунд 200.0 мянган төгрөг,

2. Сайхан ЭМТ, Номгон ЭМТ нийт 969,228.5 мянган төгрөг:

- ЭМДС-аас ковидын хэвтэн эмчлүүлэгсэд болон гэрээр эмчлүүлэгчдийн зардалд 810,888.3 мянган төгрөг,
- Эрүүл мэндийн газраас 58,467.3 мянган төгрөг,

- Эмийн орлого 63,533.9 мянган төгрөг,
- Сайхан ЭМТ-ийн өөрийн үйл ажиллагааны орлого 34,904.0 мянган төгрөг,
- Иргэд, ААНБ-ын хандив 1,435.0 мянган төгрөг,

3. Сайхан 1 дүгээр сургууль нийт 34,038.1 мянган төгрөг:

- Канад сангийн хөрөнгө оруулалтаар 17,026.6 мянган төгрөг,
- Боловсролын газраас БЧШ төслийн санхүүжилт 11,627.9 мянган төгрөг,
- Өөрийн үйл ажиллагааны орлого 5,383.6 мянган төгрөг,

4. Сайхан 2 дугаар сургууль нийт 10,682.0 мянган төгрөг:

- Боловсролын газраас БЧШ төслийн санхүүжилт 10,480.0 мянган төгрөг.
- Боловсролын газраас Ковид-19 цар тахлын үед хийх ариутгал халдваргүйтгэлийн ажлын санхүүжилт 202,0 мянган төгрөг,

5. Номгон ЕБСургууль нийт 13,972.0 мянган төгрөг:

- Төгсөгчдийн хандив 13,615.0 мянган төгрөг,
- Боловсролын газраас Ковид-19 цар тахлын үед хийх ариутгал халдваргүйтгэлийн ажлын санхүүжилт 357.0 мянган төгрөг,

6. Сайхан сумын 1,2,3,4-р Цэцэрлэг нийт 1,285.0 мянган төгрөг:

- Боловсролын газраас Ковид-19 цар тахлын үед хийх ариутгал халдваргүйтгэлийн ажлын санхүүжилт 1,285.0 мянган төгрөг,

7. ИТХурал нийт 600.0 мянган төгрөг:

- Сэлэнгэ аймгийн ИТХ-аас Сумын хамтарсан багийн бичиг хэргийн зардлын санхүүжилт 600.0 мянган төгрөг,

8. Номгон Захирагчийн алба нийт 800.0 мянган төгрөг:

- Сэлэнгэ аймгийн ИТХ-аас хамтарсан багийн бичиг хэргийн санхүүжилт 300.0 мянган төгрөг,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/368 тоот захирамжаар Мал эмнэлгийн газраас малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилт 500.0 мянган төгрөг,

9. Хөтөл Соёлын ордон нийт 3,654.1 мянган төгрөг :

- Үндсэн үйл ажиллагааны орлого 3,654.1 мянган төгрөг,

10. Номгон Соёлын төв нийт 118.5 мянган төгрөг:

Үндсэн үйл ажиллагааны орлого 118.5 мянган төгрөг

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогыг дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Цалин болон нэмэгдэл урамшил, НДШ зардалд 265,462.1 мянган төгрөг,
- Хангамж бараа материалын зардалд 43,266.1 мянган төгрөг,
- Нормативт зардалд 410,220.8 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 59,755.7 мянган төгрөг,
- Дотоод албан томилолтын зардалд 439.4 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 57,961.3 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардалд 36,005.4 мянган төгрөг,
- Бусад урсгал шилжүүлгийн зардалд 110,600.0 мянган төгрөг,
- Хөрөнгө худалдан авахад 92,065.7 мянган төгрөгийг зарцуулж, 10,843.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Иргэд, аж ахуйн нэгжийн хог хаягдлын хураамжийн өглөг, авлагын үлдэгдлийг хог хаягдлын хураамж хариуцсан байцаагч нар өөрсдийн хувийн тооцоогоор хянаж, тэдний тушаасан мөнгөний хэмжээгээр орлогыг тооцож байгаа бөгөөд байцаагчид бэлнээр хураасан хураамжийг харилцах дансанд бүрэн төвлөрүүлж буй эсэхэд бүртгэлээр тавих хяналт сул байна. Цаашид байцаагчдын төвлөрүүлсэн хог хаягдлын хураамжийн тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Сайхан 1 дүгээр сургууль, Номгон тосгоны ЭМТ нь тайлант жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийж хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагууд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 99 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг огт мэдээлээгүй, 40 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 16 удаа хугацаа хоцроож, 3 удаа огт мэдээлээгүй,

- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 13 удаа хугацаа хоцроож, 5 удаа огт мэдээлээгүй,
- Бусад мэдээллийг 11 удаа хугацаа хоцроож, 4 удаа огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

1.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1.Сайхан сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 8,960,832.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 8,531,711.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.8 хувиар хэмнэсэн байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- Сумын Соёлын ордны тайлант оны үйл ажиллагаанд 475,322.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 473,406.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.4 хувиар хэмнэсэн,
- Номгон тосгоны Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 116,076.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 110,319.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.0 хувиар хэмнэсэн,

Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2. ЗДТГ нь төрийн жинхэнэ албан хаагчдад 3,750.0 мянган төгрөгийн албаны дүрэмт хувцас хийлгүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 тогтоолын 1.4 дэх “ Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, **албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 29091.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 250.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 7 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	250.0	1	250.0			100.0

Албан шаардлага	2	8,098.5	2	8,098.5			100.0
Зөвлөмж	4	20,742.5	2	4,686.7	2	16,055.8	50.0
Нийт	7	29091.0	5	10,014.6	3	16,055.8	71.4

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Сайхан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар өгсөн төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийг нэмэгдүүлэн батлахгүй байх, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 15 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 17 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Сайхан сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,247,015.6 мянган төгрөгийн 51 алдаа, зөрчил илрүүлснээс 190,868.7 мянган төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 16,504.4 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 115,108.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 19 зөрчилд албан шаардлага, 924,533.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 8 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 517,554.2 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илрүүлснээс 15,994.2 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 112,257.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 зөрчилд албан шаардлага, 389,302.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт:

1. ЗДТГ нь баяр наадмын зардлын хэмнэлтээс төрийн жинхэнэ албан хаагчдад 3,750.0 мянган төгрөгийн албаны дүрэмт хувцас захиалж, хийлгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 тогтоолын 1.4 дэх “ Энэ тогтоол батлагдахаас өмнө ... худалдан авах ажиллагаа зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, ...худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дүрэмт хувцасны үнийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Номгон тосгоны ЭМТ нь эмийн тооцоо, тооллогыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн, үлдэгдлийг баталгаажуулдаггүйгээс нийт 2,328.0 мянган төгрөгийн / эмнэлгийн дотоод эм 187.3 мянган төгрөг, эмийн сангийн эм 2,140.7 мянган төгрөг / эмийн дутагдап үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн дутагдлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

3. Номгон тосгоны ЭМТ-ийн эмийн сангийн эмийн орлого нь шилжүүлсэн төлбөрөөс 9,916.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан буюу төлбөрийг гүйцэтгэсэн эм бэлтгэн нийлүүлэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн орлогоос илүү шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага:

ЗДТГ:

1. Батлагдсан төсвөөс тус суманд албан томилолтоор ажилласан аймгийн МЭГ-ын ажилтнуудын зочид буудлын хөлс 60.0 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 12,486.0 мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно, 13.7 дахь " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 5.2 дахь "Тухайн шатны ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.0

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан:

3. ИТХ-аар баталсан төсвийн санхүүжилтийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд 39,211.5 мянган төгрөгөөр илүү тусгаж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-аар баталсан төсвийн төлөвлөгөөг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлэх албан шаардлага хүргүүлэх.

4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ИТХ-ын ажлын албанд компьютер, тоног төхөөрөмж худалдан авах 2,000.0 мянган төгрөг, ЗДТГ-т Apple air 10.9 маркийн төхөөрөмж худалдан авах 4000.0 мянган төгрөг, урсгал засварт 14,000.0 мянган төгрөг, Аврах гал унтраах 67-р ангид 2,880.0 мянган төгрөг, өмгөөллийн хөлс 2,000.0 мянган төгрөг зэрэг хөрөнгийн болон урсгал зардлыг нийт 24,880.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь "Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ", 34.2.2: "Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон" гэсэн

заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5. ИТХ нь Хөтөл дент шүдний эмнэлэгт 300.0 мянган төгрөг, ХБИ-ийн хоол хүнсний дэмжлэгт 200.0 мянган төгрөг зэрэг нийт 500.0 мянган төгрөгийн хандив өгсөн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусдад хандив өгөхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

6. Номгон тосгоны Соёлын төв нь эрхлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламжтай давхардуулан 895.9 мянган төгрөгийн тусламжийг цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх,

Номгон тосгоны ЭМТ:

7. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу хөтлөөгүй, анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй дараах ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.1: “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөл бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 4,941.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Эмийн сангийн 2,372.2 мянган төгрөгийн эмийн худалдан авалтыг эмийн тайланд орлого авалгүйгээр зарцуулсан буюу шууд зарлагдсан,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ЭМТ-ийн даргад 1,279.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон,
- Эмийн сангийн 18,943.5 мянган төгрөгийн эмийн борлуулалтыг зарлагаар бүртгэлгүйгээр үлдэгдлээр тайлагнасан,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу хөтлөх, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх болон анхан шатны баримтыг үндэслэн санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргаж байх албан шаардлага хүргүүлэх.

8. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын 511.8 мянган төгрөгийн, НДШ-ийн 193.9 мянган төгрөгийн зэрэг нийт 705.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь " *Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

9. 3 албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 2,100.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх "*Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг ... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна*" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлэх, зайлшгүй тохиолдолд холбогдох албан тушаалтны шийдвэрээр хууль эрхийн актад нийцсэн урамшуулал олгож байх албан шаардлага хүргүүлэх.

10. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллого хийж хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь " *Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ*", 12.2.1: " *Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө* " гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийж байх албан шаардлага хүргүүлэх.

11.ЭМТ -ийн дарга, нягтлан бодогч нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа зөрчлийг давтан гаргасан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсөв санхүүгийн их хэмжээний материаллаг алдаа зөрчил гаргасан зэргээр албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зэрэг алдаа зөрчлийг давтан гаргасан дарга А.Батгэрэл, нягтлан бодогч Б.Батчимэг нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

12. Сумын Соёлын ордон нь нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлснээс нь 2,307.0 мянган төгрөгийн авлага, бараа материалын төлбөрийг дутуу шилжүүлж 1,610.1 мянган төгрөгийн өр төлбөр зэрэг нийт 3,917.1 мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 389,302.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь халаалтын зардлаас 180.9 мянган төгрөгийн шатахуун, Номгон ЭМТ нь бичиг хэргийн зардлаас 189.0 мянган төгрөгийн аж ахуйн материал зэрэг нийт 369.9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”. 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх.

2.Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд нь ЗДТГ 55,042.9 мянган төгрөгийн , Сайхан ИТХ 3,752.9 мянган төгрөгийн, Номгон Захирагчийн алба 17,174.2 мянган төгрөгийн, Номгон ЭМТ 29,765.9 мянган төгрөгийн, Сайхан Соёлын төв 20,208.1 мянган төгрөгийн, Номгон Соёлын төв 657.3 мянган төгрөгийн, Хот тохижуулах газар 7,942.7 мянган төгрөгийн зэрэг нийт 134,544.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нэтлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”* гэж заасныг зөрчсөн ба *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: СХС хариуцсан мэргэжилтэн зээлийн эхний үлдэгдлийг үнэн зөв бүртгэж байгаагүйгээс 42,945.4 мянган төгрөгийн авлагыг илүү , Номгон тосгоны Захирагчийн алба нь цалингийн санг 222.1 мянган төгрөгөөр зөрүүтэй, Номгон ЭМТ нь эмийн эхний үлдэгдлийг өртгөөр нь бус худалдах үнээр тусгаснаас 2,483.8 мянган төгрөгөөр хөрөнгийн үлдэгдлийг өсгөж, санхүүгийн тайланд тус тус тусгасан байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв заргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийнч *“Үнэлгээ ба хуваарилалт”* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд 2022 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулга хийх,

4. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал:

4.1. Илрүүлэлт: Номгон тосгоны цэцэрлэг нь УТХО-р хийгдсэн 208,737.5 мянган төгрөгийн өртөг бүхий дээврийн их засварын ажлын дүнгээр хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд 14.4.1 *“Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”*, 14.4.2 *“Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”*, 14.4.6 *“Бүх зардал”*

зэргийг заавал тусгана гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд 2022 оны эхний хагас жилд багтаан хөрөнгийг капиталжуулж бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс						Зөвлөмж			
		Зөрчлүүл		Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах		Албан шаардлага					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ЗДТГ нь баяр наадмын зардлын хэмнэлтээс төрийн жинхэнэ албан хаагчдад албаны дүрэмт хувцас захиалж, хийлүүлсэн	1	3,750.0	1	3,750.0								
2	Номгон тосгоны ЭМТ нь эмийн дутагдал үүсгэсэн	1	2,328.0	1	2,328.0								
3	Номгон тосгоны ЭМТ-ийн эмийн сангийн эмийн орлого нь шилжүүлсэн төлбөрөөс дутуу тайлагнагдсан буюу төлбөрийг гүйцэтгэсэн эм бэлтгэн нийлүүлэгдээгүй.	1	9,916.2	1	9,916.2								
1	ЗДТГ нь батлагдсан төсвөөс тус суманд албан томилолтоор ажилласан аймгийн МЭГ-ын ажилтнуудын зочид буудлын хөлс төлсөн	1	60.0					1	60.0				
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс анхан шатны баримтын бүрдэлгүйгээр, зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан байна	1	12,486.0					1	12,486.0				
3	ИТХ-аар баталсан төсвийн санхүүжилтийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд 39,211.5 мянган төгрөгөөр илүү тусгаж, тайлагнасан	1	39,211.5					1	39,211.5				
4	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна	1	24,880.0					1	24,880.0				
5	ИТХ нь хандив өгсөн.	1	500.0					1	500.0				
6	Номгон тосгоны Соёлын төв нь тэтгэвэрт гарахад олгох нэг	1	859.9					1	859.9				

